




ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2024 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ

УЛААНБААТАР 2025


Эмхэтгэлийг боловсруулсан:

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ЗАХ ЗЭЭЛ ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР  
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

 [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn)


 11-304258

2025 он





## АГУУЛГА

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт .....	5
Зурган мэдээллийн жагсаалт.....	7
<b>1. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>10</b>
<b>2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ.....</b>	<b>18</b>
<b>3. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....</b>	<b>20</b>
3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого.....	20
3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого .....	21
3.3 Хөрөнгө оруулалт.....	23
<b>4. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ.....</b>	<b>24</b>
4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт.....	25
4.2 Харилцаа холбооны сүлжээний урт.....	26
4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ.....	27
4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ .....	27
4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ .....	28
<b>5. ҮҮРЭН ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ.....</b>	<b>29</b>
5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт .....	29
5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо .....	31
5.3 Үүрэн холбооны ачаалал/ хэрэглээ.....	37
5.3.1 Ярианы ачаалал.....	37
5.3.2 Мессеж ба дата хэрэглээ .....	38
<b>6. СУУРИН ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭ.....</b>	<b>40</b>
6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого .....	40
6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо .....	42
6.3 Суурин интернэтийн хэрэглээ.....	45
<b>7. СУУРИН ТЕЛЕФОН ҮЙЛЧИЛГЭЭ.....</b>	<b>46</b>
7.1 Суурин телефон үйлчилгээний орлого.....	46
7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо.....	48
7.3 Суурин телефон ярианы ачаалал.....	49
<b>8. ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ - ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>51</b>
8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого.....	51
8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо .....	53
<b>9. ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>57</b>
<b>10. РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>60</b>




<b>11. ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b> .....	<b>62</b>
11.1 Шуудангийн үйлчилгээний орлого.....	63
11.2 Шуудангийн илгээмж солилцоо.....	65
11.2.1 Дотоодын шуудангийн илгээмж солилцоо.....	65
11.2.2 Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо.....	66
<b>12. ХҮНИЙ НӨӨЦ</b> .....	<b>68</b>
Хавсралт.....	70







## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор.....	18
Хүснэгт 2.	Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр	19
Хүснэгт 3.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, .....	21
Хүснэгт 4.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр .....	22
Хүснэгт 5.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр.....	23
Хүснэгт 6.	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний хүртээмжээр, 2024 .....	24
Хүснэгт 7.	Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд .....	25
Хүснэгт 8.	Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр .....	25
Хүснэгт 9.	Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор	26
Хүснэгт 10.	Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор.....	28
Хүснэгт 11.	Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэгчдийн орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр .....	28
Хүснэгт 12.	Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо.....	28
Хүснэгт 13.	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь.....	29
Хүснэгт 14.	Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр	30
Хүснэгт 15.	Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлого, оноор .....	30
Хүснэгт 16.	Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин.....	31
Хүснэгт 17.	Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо, оноор .....	32
Хүснэгт 18.	Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо .....	33
Хүснэгт 19.	Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр.....	35
Хүснэгт 20.	Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар, 2024 он.....	36
Хүснэгт 21.	Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ...	39
Хүснэгт 22.	Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор.....	40
Хүснэгт 23.	Суурин интернэт үйлчилгээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр .....	40
Хүснэгт 24.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар .....	44
Хүснэгт 25.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр .....	44
Хүснэгт 26.	Суурин интернэт үйлчилгээний дата хэрэглээ, оноор.....	45
Хүснэгт 27.	Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2024 он .....	46
Хүснэгт 28.	Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр.....	46
Хүснэгт 29.	Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор .....	48
Хүснэгт 30.	Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, төрлөөр.....	48
Хүснэгт 31.	Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр, 2024 он .....	49
Хүснэгт 32.	Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор .....	49
Хүснэгт 33.	Суурин телефон хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр.....	49
Хүснэгт 34.	Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2024 он .....	51




<b>Хүснэгт 35.</b> Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр .....	52
<b>Хүснэгт 36.</b> АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр .....	55
<b>Хүснэгт 37.</b> Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2024 он .....	56
<b>Хүснэгт 38.</b> Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр, 2024 он.....	57
<b>Хүснэгт 39.</b> Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт,.....	58
<b>Хүснэгт 40.</b> Телевизийн үйлчилгээний 2024 оны орлого /Тэрбум төгрөг/.....	58
<b>Хүснэгт 41.</b> Телевизийн үйлчилгээний орлогын бүтэц.....	58
<b>Хүснэгт 42.</b> Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 2024 оны орлогын бүтэц.....	59
<b>Хүснэгт 43.</b> Арилжааны телевизүүдийн 2024 оны орлогын бүтэц.....	59
<b>Хүснэгт 44.</b> Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр.....	60
<b>Хүснэгт 45.</b> Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр.....	61
<b>Хүснэгт 46.</b> Радиогийн үйлчилгээний 2024 оны орлого, байршлаар.....	61
<b>Хүснэгт 47.</b> Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2024 он.....	61
<b>Хүснэгт 48.</b> Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо .....	62
<b>Хүснэгт 49.</b> Шуудангийн сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2024 .....	62
<b>Хүснэгт 50.</b> Улс хоорондын илгээмжийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо, 2024 он.....	63
<b>Хүснэгт 51.</b> Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр.....	63
<b>Хүснэгт 52.</b> Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо .....	65
<b>Хүснэгт 53.</b> Дотоодын шуудангийн илгээмж солилцоо, илгээмжийн төрлөөр, 2024 он.....	65
<b>Хүснэгт 54.</b> Дотоодын шуудангийн илгээмж солилцоо, оноор.....	66
<b>Хүснэгт 55.</b> Дотоодын буухиа шуудан солилцоо, оноор.....	66
<b>Хүснэгт 56.</b> Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо, илгээмжийн төрлөөр, 2024 он.....	66
<b>Хүснэгт 57.</b> Улс хоорондын шуудан солилцоо, чиглэлээр, 2024 он.....	68
<b>Хүснэгт 58.</b> Улс хоорондын шуудан солилцооны тоо.....	67
<b>Хүснэгт 59.</b> Улс хоорондын буухиа шуудан солилцоо .....	67
<b>Хүснэгт 60.</b> Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр, оноор.....	68






## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Зөвшөөрлийн тоо, оноор.....	18
Зураг 2.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2021-2024 он.....	20
Зураг 3.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор.....	20
Зураг 4.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор ..	22
Зураг 5.	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор ..	23
Зураг 6.	Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор.....	25
Зураг 7.	Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2024.....	26
Зураг 8.	Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж: Гбит/сек ...	27
Зураг 9.	Үүрэн холбооны үйлчилгээний орлого, оноор.....	29
Зураг 10.	Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) .....	31
Зураг 11.	Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор .....	31
Зураг 12.	Хэрэглэгчийн төлбөрийн нөхцлөөр зах зээлд эзлэх хувь, оноор .....	32
Зураг 13.	3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян .....	33
Зураг 14.	Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр .....	33
Зураг 15.	Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, аймгаар, 2024 он .....	34
Зураг 16.	Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, аймгаар, 2024 он.....	34
Зураг 17.	M2M хэрэглэгчийн тоо, оноор .....	35
Зураг 18.	Ухаалаг төхөөрөмжийн төрөл, 2024 он .....	37
Зураг 19.	Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо .....	37
Зураг 20.	Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут.....	38
Зураг 21.	Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ /ТВ/.....	38
Зураг 22.	Үүрэн холбооны хэрэглэгчийн сарын мессеж болон дата хэрэглээ .....	39
Зураг 23.	Суурин интернэт үйлчилгээний нийт орлого .....	41
Зураг 24.	Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц, 2024 он.....	41
Зураг 25.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо .....	42
Зураг 26.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар.....	42
Зураг 27.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр.....	43
Зураг 28.	Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар.....	43
Зураг 29.	Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ, оноор .....	45
Зураг 30.	Суурин телефон үйлчилгээний нийт орлого, оноор.....	47
Зураг 31.	Суурин телефон холбооны орлогын бүтэц 2024 он.....	47
Зураг 32.	Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU), оноор .....	47
Зураг 33.	Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор.....	48
Зураг 34.	Суурин холбооны ярианы ачаалал, оноор.....	50
Зураг 35.	Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого.....	52
Зураг 36.	Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU), оноор .....	52
Зураг 37.	Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор .....	53
Зураг 38.	Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор .....	53



Зураг 39. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр.....	54
Зураг 40. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор, 2024 он .....	54
Зураг 41. АйПиТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор.....	54
Зураг 42. АйПиТВ хэрэглэгчийн тоо, байршлаар, оноор.....	55
Зураг 43. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого /тэрбум төгрөг/ .....	57
Зураг 44. Радиогийн үйлчилгээний орлого, оноор.....	60
Зураг 45. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор .....	64
Зураг 46. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц, эзлэх хувиар .....	64
Зураг 47. Шуудангийн илгээмж солилцоо, оноор .....	65
Зураг 48. Нийт ажилтны тоо, оноор .....	68
Зураг 49. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр, 2024 он .....	69
 Хавсралт	
Хавсралт 1. Хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2024 он.....	70
Хавсралт 2. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, сүүлийн 2 жилээр .....	71
Хавсралт 3. 2024 оны жилийн эцсийн тайлангийн ирц.....	73





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН

# 2024 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ



Дамжуулах сүлжээний урт

**53,540 км** ▲ 3.08%



Интернэтийн гадаад урсгалын багтаамж

**750 Гбит/сек** ▲ 27.01%



Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч

**4,889,043** ▲ 0.97%



100 хүнд ногдох үүрэн холбооны хэрэглэгч

**137.9** ▼ 0.17 н.х



Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч

**4,137,353** ▲ 0.36%



100 хүнд ногдох хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч

**116.7** ▲ 2 н.х



Суурин холбооны нийт (төлбөр төлсөн) идэвхтэй хэрэглэгч

**621,228** ▲ 18.54%



100 хүнд ногдох суурин холбооны хэрэглэгч

**17.5** ▲ 3.4 н.х



Суурин интернэтийн идэвхтэй хэрэглэгч

**546,213** ▲ 9.49%



Нийт өрхийн интернэтэд холбогдсон хувь

**51.8%** ▲ 4.6 н.х



Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгч (Үүнд OTT үйлчилгээний хэрэглэгч ороогүй болно.)

**753,795** ▼ 1.05%



Нийт өрхийн олон суваг дамжуулах үйлчилгээ авч буй хувь

**76.65%** ▼ 1.05 н.х



IPTV үйлчилгээний идэвхтэй хэрэглэгч

**466,923** ▲ 8.82%



Интернэтээр дамжуулан олон суваг дамжуулах үйлчилгээ авч буй (OTT) идэвхтэй хэрэглэгч

**152,556**



Дотоодын шуудан солилцоо

**2,073,918 ш** ▼ 17.02%



Улс хоорондын шуудан солилцоо

**875,623 ш** ▲ 61.06%



Орлого

**₮2,408.4 тэрбум** ▲ 14.08%



Хөрөнгө оруулалт

**₮352.0 тэрбум** ▲ 4.1%



Төсөвт төвлөрүүлсэн орлого

**₮384.3 тэрбум** ▲ 7.82%



Хүний нөөц

**12,200** ▼ 0.3%

## 1. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тусгай зөвшөөрлийн гэрээ болон “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх журам”-ын 4.3-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн тайлан мэдээллийг [www.stat.crc.gov.mn](http://www.stat.crc.gov.mn) цахим системээр цуглуулан авч, мэдээллийг нэгтгэн танилцуулж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх 754 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 86.07% нь тайлан мэдээгээ ирүүлсэн бол тайлбар албан бичиг ирүүлсэн 85, тайлан ирүүлээгүй 105 байна.




Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого 2024 оны байдлаар 2.4 их наядад хүрсэн нь өмнөх оноос 14.79 хувиар, төсөвт төвлөрүүлсэн орлого 384.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 7.82 хувиар тус тус өссөн. Нийт хөрөнгө оруулалт 352.0 орчим тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.11 хувиар өссөн байна.

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээнд нийт 12,200 ажилтан ажиллаж байна. Нийт ажилтны тоо өмнөх оноос 0.3 хувиар буурчээ. Нийт ажилтны 62.4 хувь нь мэдээлэл, харилцаа холбоонд, 24.65 хувь нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд, 12.93 хувь нь шуудангийн үйлчилгээнд хамаарч байна.

# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ

## 2024 ОН



Монгол Улсын дамжуулах сүлжээний урт 53,540 км болж 2023 оноос 3.08 хувиар нэмэгджээ. Үүнээс шилэн кабелийн сүлжээ 46,512 км ба хот хоорондын шилэн кабелийн сүлжээний урт 43,132 км байна. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний 46.13 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК эзэмшиж байна.

Интернэтийн гадаад урсгалын багтаамж 2024 оны жилийн эцэст 750.0 Гбит/сек болсон нь 2023 оны жилийн эцсийн үеэс 159.5 Гбит/сек-ээр буюу 27.01 хувиар нэмэгджээ. Харин интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд гэрээлсэн урсгал 228.7 Гбит/сек ба 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 7.16 хувиар нэмэгдсэн байна.


Улс хоорондын транзит урсгалын багтаамж 2023 оны жилийн эцсээс хойш 400 Гбит/сек-ээр нэмэгдэж, 2200 Гбит/сек болсон байна.





Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч 2024 оны жилийн эцсийн байдлаар 4,889,043 болж өмнөх оноос 0.97 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ногдох үзүүлэлт нь 137.9 болж өмнөх оноос 0.17 хувиар буурчээ.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 60.64 хувийг урьдчилсан төлбөрт, 27.19 хувийг дараа төлбөрт, 12.17 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байгаа бөгөөд жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт үйлчилгээ руу шилжиж байна.

Үүрэн холбооны сүлжээнд ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо 4.80 хувиар өсч, 4,283,341 болсон байна. Үүнээс Андроид утас хэрэглэгч 64.59 хувь, iOS утас хэрэглэгч 32.22 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд iOS буюу iPhone утас хэрэглэгчийн хувь нэмэгдэж байна.



# ҮҮРЭН ХОЛБООНЫ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО БА ДАТА ХЭРЭГЛЭЭ /ТЕХНОЛОГИЙН ТӨРЛӨӨР/ 2024 ОН




Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт хэрэглэгчийн тоо 4,137,353 болж өмнөх оноос 0.36 хувиар өссөн. Энэ нь үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 84.63 хувь нь интернэт хэрэглэж байгааг харуулж байна.

Үүрэн холбооны 3G сүлжээн дэх хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 7.35 хувиар, 4G сүлжээн дэх хэрэглэгчийн тоо 17.13 хувиар тус тус өссөн ба 4G сүлжээн дэх хэрэглэгч 3G сүлжээний хэрэглэгчээс илүү болсон байна.

3G сүлжээн дэх дата хэрэглээ 54,403 Терабайт болж өмнөх онтой харьцуулахад 10.76 хувиар өссөн бол 4G сүлжээнд 711,577 Терабайт болж 16.22 хувиар, нийт дүнгээр 15.8 хувиар тус тус өсчээ. Дата хэрэглээний хэмжээ жил бүр өсч байгаа ч өсөлтийн хувь нь 2023 онтой харьцуулахад 12.4 нэгж хувиар буурчээ.

2024 онд нэг хэрэглэгчийн нэг сарын дундаж дата хэрэглээ 15.43 Гбайт байгаа нь 2023 онтой харьцуулахад 2.06 Гбайтаар (15.39%) нэмэгджээ.




### СУУРИН ТЕЛЕФОН ХОЛБОО

2024 ОН



#### ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Төлбөр төлсөн, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор тооцсон.

#### ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО




#### ЯРИАНЫ АЧААЛАЛ



Суурин телефон холбооны төлбөр төлж буй идэвхтэй хэрэглэгчийн тоо 621,228 болсон нь 2023 оны жилийн эцсээс 18.54 хувиар өсчээ. Эдгээр хэрэглэгчийн 71.63 хувь нь АйПиТВ хосолсон үйлчилгээний хэрэглэгч байна.

Суурин телефон холбооны хэрэглэгчийг технологийн төрлөөр нь авч үзвэл уламжлалт (NGN) сүлжээний хэрэглэгч 4.86 (30,208) хувь, интернэт протоколд суурилсан сүлжээний (VoIP) хэрэглэгч 78.71 (488,961) хувь, интернэт сүлжээний (OTT) хэрэглэгч 16.43 (102,059) хувийг эзэлж, интернэт сүлжээний (OTT) хэрэглэгчийн тоо нэмэгдэж байна. Гэрээний төрлөөр нь авч үзвэл өрхийн хэрэглэгч 90.4 хувь (561,515), байгууллагын хэрэглэгч 9.6 (59,713) хувийг тус тус эзэлж байна. Суурин телефон холбооны өрхийн хэрэглэгчийн тоо 2023 онтой харьцуулахад 18.2 хувиар, байгууллагын хэрэглэгчийн тоо 22.0 хувиар тус тус өсчээ.

Суурин телефон холбооны сүлжээнд сүүлийн 3 сар ярианы ачаалал үүсгэсэн 145,457 хэрэглэгч байгаа нь өмнөх онтой харьцуулахад 22.1 хувиар буурсан байна. Ачаалал үүсгэсэн хэрэглэгч нь нийт хэрэглэгчийн 23.41 хувийг эзэлж байна.



## СУУРИН ИНТЕРНЭТ

2024 ОН



### ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО

**546,213** +9.5%

**51.8%** +4.6 нх  
Суурин интернэтэд холбогдсон өрх

**205.7 Гбайт** +16.7%  
Нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ


### ГЭРЭЭНИЙ ТӨРЛӨӨР

**94.63%**  
Өрх


**4.67%**  
Аж ахуйн нэгж

**0.70%**  
Төсвийн байгууллага


### БАЙРШЛААР



### ТЕХНОЛОГИЙН ТӨРЛӨӨР



### ГЭРЭЭТ ХУРДААР




Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон хэрэглэгчийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 546,213 -д хүрч өмнөх оноос 9.49 хувиар өссөн байна. Үүний 516,893 (94.63%) нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 51.8 хувь нь суурин интернэтэд холбогдсон байна.

Нийт суурин интернэт хэрэглэгчийн 75.05 хувь нь Улаанбаатар хотод, 24.95 хувь нь хөдөө орон нутагт байршилтай байна. Суурин интернэт хэрэглэгчийн тоо Улаанбаатар хотод 8.07, орон нутагт 13.96 хувиар тус тус нэмэгджээ.

Суурин интернэтийн хэрэглээ, гэрээт хурдны хэмжээ жил бүр нэмэгдэж буй бөгөөд 2024 оны жилийн эцсийн тоон мэдээллээр нийт хэрэглэгчийн 95.54 хувь нь 10 Мбит/сек-ээс дээш хурдаар, 39.1 хувь нь 10-30 Мбит/сек хурдаар, 55.1 хувь нь 30-100 Мбит/сек хурдаар интернэтийн үйлчилгээ авч байна.

2024 онд нийт суурин интернэт хэрэглэгчийн үүсгэсэн нийт (upload, download) интернэт ачаалал 1.35 EB (экзабайт) хүрсэн нь 2023 оноос 27.8%-иар өссөн. Суурин интернэтийн нэг хэрэглэгч нэг сард дунджаар 205.7 Гбайт дата хэрэглэсэн нь өмнөх онтой харьцуулбал 16.7 хувиар нэмэгджээ.

Суурин интернэт хэрэглэгчийн 96.52 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 3.48 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна.



## ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

2024 ОН



Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний (ОСДҮ) идэвхтэй хэрэглэгч 2024 оны жилийн эцсийн байдлаар 753,795 болж өмнөх оны мөн үеэс 1.05 хувиар буурсан. (Жич: үүнд РТҮС УТҮГ болон ОТТ хэрэглэгчийн тоо ороогүй.) Идэвхтэй хэрэглэгчийн тоог нийт өрхийн тоотой харьцуулбал 76.65 хувь байгаа нь 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.05 нэгж хувиар буурчээ.

Телевизийн ОСДҮ-г технологиор нь авч үзвэл хэрэглэгчийн 61.94 хувь нь (466,932) АйПиТВ-ээр, 30.98 хувь нь (233,517) хиймэл дагуулаар, 6.13 хувь нь (46,220) DVB-T2 утасгүй тоон сүлжээгээр, 0.95 хувь нь (7,126) уламжлалт КаТВ технологиор үйлчилгээг хүлээн авч үзэж байна.

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг интернэтээр хүлээн авч буй (ОТТ) идэвхтэй хэрэглэгчийн тоог сүүлийн 3 сарын хугацаанд төлбөр төлсөн хэрэглэгчээр тооцон гаргасан ба нийт 6 үйлчилгээний 152,556 хэрэглэгч байна.

АйПиТВ үйлчилгээний хэрэглэгч 2024 оны жилийн эцсийн байдлаар 466,932 болж 8.82 хувиар өссөн ба үүнээс 98.19 хувь нь гурвалсан үйлчилгээний хэрэглэгч байна. Бусад технологийн хэрэглэгчйн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотын хэрэглэгчийн 79.46 хувь АйПиТВ хэрэглэж байгаа бол орон нутгийн хэрэглэгчдийн 57.25 хувь нь хиймэл дагуулаар телевизийн үйлчилгээ хүлээн авч байна.



## ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2024 ОН



2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын шуудан солилцоо 2,073,918 байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.02 хувиар буурсан бол улс хоорондын орох, гарах нийт солилцоо 875,632 болж 61.06 хувиар өссөн байна.

Дотоодын шуудангийн хувьд бичиг захидлын солилцоо 86.32 хувь, боодол 4.32 хувь, илгээлт 9.36 хувийг эзэлж байна. Дотоодын нийт шуудан солилцооны 95.10 хувийг ердийн шуудан эзэлж байгаа бол 4.90 хувийг буухиа шуудан солилцоо эзэлж байна.

Нийт улс хоорондын шуудангийн 87.19 хувь нь гадаад улсаас Монгол улс руу орох шуудан эзэлж байна.

Улс хоорондын шуудангийн хувьд бичиг захидлын солилцоо 14.24 хувь, боодол 17.65 хувь, илгээлт 68.11 хувийг тус тус эзэлж байна. Улс хоорондын нийт шуудангийн 87.79 хувийг ердийн шуудан эзэлж байгаа бол 12.21 хувийг буухиа шуудан эзэлж байна.

## 2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Зохицуулах хорооноос 2024 онд нийт 128 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 47 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 58 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Хүснэгт 1-д тусгай зөвшөөрлийн шийдвэрийн талаарх мэдээллийг харуулав.


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор

Төрөл		2022 он	2023 он	2024 он
Шинээр олгосон	Хуулийн этгээд	121	126	117
	Тусгай зөвшөөрөл	176	145	128
Нэмэлт өөрчлөлт оруулсан	Хуулийн этгээд	19	13	17
	Тусгай зөвшөөрөл	29	19	19
Сэргээсэн	Хуулийн этгээд	28	48	19
	Тусгай зөвшөөрөл	34	60	27
Сунгасан	Хуулийн этгээд	113	134	104
	Тусгай зөвшөөрөл	142	160	123
Түдгэлзүүлсэн	Хуулийн этгээд	111	54	42
	Тусгай зөвшөөрөл	141	74	47
Нэр шилжүүлсэн	Хуулийн этгээд	6	3	9
	Тусгай зөвшөөрөл	11	6	14
Хүчингүй болгосон	Хуулийн этгээд	30	71	53
	Тусгай зөвшөөрөл	38	85	58

Эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан

2024 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нийт 754 болж 12 тусгай зөвшөөрлөөр буурсан, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 192 тусгай зөвшөөрөл, радио давтамж ашиглах 643 эрхийн бичиг олгогдсон байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор



Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог ерөнхий чиглэлээр нь авч үзвэл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр нийт 392, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр

237, шуудангийн чиглэлээр 125 тусгай зөвшөөрөл байна.

Тусгай зөвшөөрлийн тоог эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь Хүснэгт 2-т харуулсан бөгөөд харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь нийт тусгай зөвшөөрөлд 37.67 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна.

*Хүснэгт 2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр*

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл	2022	2023	2024	
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах	16	20	19	
	Сансрын холбооны сүлжээ байгуулах	3	3	3	
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	7	7	7
		Үүрэн холбоо	5	5	5
		Улс хоорондын яриа	4	4	4
		Суурин интернэт	61	61	59
		Сансрын хөдөлгөөнт холбоо	3	4	4
	Мэдээллийн сүлжээ	5	6	7	
	Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ	264	267	284	
		Нийт	368	377	392
Өргөн нэвтрүүлэг	Радио, телевизийн газрын сүлжээ	2	1	1	
	Олон суваг дамжуулах үйлчилгээ	31	30	28	
	Олон нийтийн телевиз	5	5	5	
	Өргөн нэвтрүүлгийн телевиз	65	63	60	
	Арилжааны телевиз	59	51	56	
	Төлбөртэй телевиз	16	20	22	
	Олон нийтийн радио	4	3	4	
	Арилжааны радио	58	55	61	
	Нийт	240	228	237	
Шуудан	Шуудангийн сүлжээ байгуулах	9	12	9	
	Дотоодын шуудангийн үйлчилгээ	Үндсэн	7	11	6
		Нэмэлт	39	30	18
	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ	Буухиа	8	10	10
		Илгээмж	65	97	9
	Нийт	144	160	125	
	НИЙТ	752	765	754	

### 3. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого 2024 оны байдлаар 2.4 их наядад хүрсэн нь өмнөх оноос 14.79 хувиар, төсөвт төвлөрүүлсэн орлого 384.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 7.82 хувиар тус тус өссөн. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2024 оны жилийн эцэст нийт 351.97 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.11 хувиар өссөн байна.

Зураг 2. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2021-2024 он




#### 3.1. Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого

Нийт дүнгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өмнөх оноос 306.1 тэрбумаар буюу 14.79 хувиар өссөн. Нийт орлого 2021 оноос хойш жигд өсөлттэй, сүүлийн 4 жилийн дундаж өсөлт 14.53 хувь байна.

Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор





Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт орлогын хамгийн их буюу 57.87 хувийг үүрэн холбооны орлого бүрдүүлж байгаа ба үүрэн холбооны үйлчилгээний орлого 2024 онд өмнөх оноос 15.81 хувиар өссөн байна.

**Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, үйл ажиллагааны чиглэлээр**

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт	
		Тэрбум төгрөг				
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах		203.33	243.77	237.00*	-2.78%
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ		8.09	7.34	7.46	1.63%
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	31.6	33.68	41.91	24.44%
		Үүрэн холбоо	1,039.76	1,190.79	1,379.02	15.81%
		Улс хоорондын яриа	2.36	0.69		
		Суурин интернэт	172.44	198.61	204.18	2.80%
	Мэдээллийн сүлжээ		8.26	7.46	7.68	2.95%
	Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ		82.83	62.66	62.35	-0.49%
Өргөн нэвтрүүлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ		181.26	212.78	277.2	30.28%
	Өргөн нэвтрүүлгийн телевиз		55.31	61.48	81.04	31.82%
	Арилжааны болон төлбөртэй телевиз		21.99	34.23	40.08*	19.19%
	Арилжааны радио		3.28	3.92	5.02	28.06%
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх		48.86	40.69	60.57	48.86%	
НИЙТ		1,859.4	2,098.1	2,404.23*	14.59%	


\* залруулсан.

**3.2. Төсөвт төвлөрүүлсэн орлого**

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого<sup>1</sup> 2024 онд 384.3 тэрбум төгрөгт хүрч, 2023 оны дүнтэй харьцуулахад 7.8 хувиар өссөн байна.

Нийт төсөвт төвлөрүүлсэн орлогын хамгийн их буюу 56.37 хувийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байна.

<sup>1</sup> Төсөвт төвлөрүүлсэн орлого гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл, Нэмүү ертгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Гаалийн татвар, Бүх нийтийн үйлчилгээний үргийн сан болон бусад татвар, хураамж хамаардаг.




Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор



Хүснэгт 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт	
		Тэрбум төгрөг				
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах	26.82	29.53	24.75	-16.2%	
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ	0.94	0.67	0.71	6.00%	
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	0.51*	1.93*	3.61	87.00%
		Үүрэн холбоо	189.53	223.22	216.64	-2.90%
		Улс хоорондын яриа	0.04	0.34		
		Суурин интернэт	4.63*	9.70*	22.70	134.00%
	Мэдээллийн сүлжээ	5.25	1.61	0.04	-97.50%	
Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ	24.87	10.44	12.31	17.90%		
Өргөн нэвтрүүлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ	48.8	50.81	50.10	-1.4%	
	Өргөн нэвтрүүлгийн телевиз	10.04	12.74	30.80	141.80%	
	Арилжааны болон төлбөртэй телевиз	5.76	7.77	10.99	41.40%	
	Арилжааны радио	0.6	1.06	1.65	55.70%	
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх		6.69	6.6	9.99	51.40%	
НИЙТ		324.47	356.44	384.29	7.80%	

\*2022, 2023 оны дүнд гурвалсан үйлчилгээ үзүүлдэг компаниудын дүн ороогүй болно.



### 3.3. Хөрөнгө оруулалт

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчид 2024 онд 351.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь 2023 оны дүнгээс 13.9 тэрбумаар нэмэгдэж 4.1 хувиар өссөн байна. Нийт хөрөнгө оруулалтын 61.55 хувийг (216.6 тэрбум төгрөг) үүрэн холбооны сүлжээ, үйлчилгээнд, 21.65 хувийг (76.19 тэрбум төгрөг) харилцаа холбооны сүлжээ байгуулахад зориулсан байна.


Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор



Хүснэгт 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр

Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт	
		Тэрбум төгрөг				
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ байгуулах	48.85	32.84	76.19	132.0%	
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ		0.09			
	Харилцаа холбооны үйлчилгээ	Суурин холбоо	0.74*		2.57	
		Үүрэн холбоо	243.6	268.41	216.64	-19.30%
		Улс хоорондын яриа				
		Суурин интернэт	10.09*	2.33*	7.19	208.60%
	Мэдээллийн сүлжээ		0.19	0.6	215.80%	
Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ	6.9	4.02	6.01	49.50%		
Өргөн нэвтрүүлэг	Олон суваг дамжуулах үйлчилгээ	25.90	19.25	13.67	-28.99%	
	Өргөн нэвтрүүлгийн телевиз	7.47	3.99	9.15	129.30%	
	Арилжааны болон төлбөртэй телевиз	11.77	1.22	6.83	459.80%	
	Арилжааны радио	0.61	1.14	0.84	-26.30%	
Шуудангийн сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх		10.89	4.6	12.29	167.20%	
НИЙТ		366.82	338.06	351.57	4.00%	

\*2022, 2023 оны дүнд гурвалсан үйлчилгээ үзүүлдэг компаниудын дүн ороогүй болно.



#### 4. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ

2024 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг (шуудангийн сүлжээг оруулахгүйгээр) нийт 12 аж ахуйн нэгж эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байна.

Харилцаа холбооны тухай хуульд (2023 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр) нэмэлт өөрчлөлт орсноор Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог ЦХИХХЯ-аас тогтоож<sup>2</sup>, сонгон шалгаруулах журмаар олгохоор зохицуулсан<sup>3</sup> ба 2024 онд энэ төрөлд шинээр тусгай зөвшөөрөл олгоогүй байна.

*Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний хүртээмжээр, 2024*

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний хүртээмж
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
2	Мобиком нэтворкс ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
3	Жемнэт ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
4	МТ Нэтворкс ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд /Транзит
5	Айрон товер ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд
6	Эс Ти Би Эс ХХК	Хот, хот хооронд
7	Скайнэтворкс ХХК	Хот, хот хооронд
8	Скайстрим ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд
9	Ийзи гөү рөүд ХХК	Хот, хот хооронд/ Улс хооронд
10	Ондо нэтворк ХХК	Хот, хот хооронд
11	Юни трансмишн нэтворк ХХК	Хот, хот хооронд
12	Согно телеком ХХК	Хот, хот хооронд


Жич: 2024 онд ЭсТиБиЭс ХХК-ийн үйлчилгээний хүртээмжид<sup>4</sup> өөрчлөлт орж, улс хоорондын үйлчилгээ нь хасагдсан.

Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчид зах зээлд дараах төрлийн бөөний үйлчилгээг үзүүлж байна.

<sup>2</sup> 6.1.18.зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн Зохицуулах хорооны саналыг харгалзан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн хувь, хэмжээг тогтоох;"

<sup>3</sup> 14.3.Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах журмаар олгоно. Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

<sup>4</sup> 3.1.21."үйлчилгээний хүртээмж" гэж чанар, стандартын шаардлага хангасан харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний төрлийг.



## Хүснэгт 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд

Хот, хот хооронд	Улс хооронд/транзит
<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн кабелийн шөрмөс түрээслүүлэх</li> <li>- Тоон суваг түрээслүүлэх (E1 суваг, дата суваг)</li> <li>- Худаг, сувагчлал түрээслүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Интернэтийн бөөний урсгалын үйлчилгээ</li> <li>- Улс хоорондын транзит үйлчилгээ</li> <li>- Улс хоорондын түрээсийн шугам</li> </ul>


## 4.1. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2024 оны нийт орлого 237 тэрбум болж өмнөх оноос 2.78 хувиар буурсан байна. Орлого буурахад улс хоорондын сүлжээний үйлчилгээний орлого буурсан нь нөлөө үзүүлжээ.

Сүлжээний үйлчилгээний нийт орлогын 73.02 хувийг хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого эзэлж байна.

Хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого өмнөх оноос 7.52 хувиар өссөн бол улс хооронд, транзит үйлчилгээний орлого 22.79 хувиар тус тус буурсан байна.

Зураг 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор



Сүлжээний үйлчилгээнд 76.19 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оноос 2.3 дахин өссөн байна. 2023 онд 8 компани хөрөнгө оруулалт хийсэн бол 2024 онд 6 компани хөрөнгө оруулалт хийсэн байна.

## Хүснэгт 8. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлт	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	203.33	243.77	237.00	-2.78%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	26.82	29.54	24.75	-16.2%
Хөрөнгө оруулалт	48.85	32.83	76.19	132.0%

#### 4.2. Харилцаа холбооны сүлжээний урт

Монгол Улсын дамжуулах сүлжээний урт 53,540 км болж 2023 оноос 3.08 хувиар нэмэгджээ. Сүлжээний уртыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хүснэгт 9-д харуулав.

Хүснэгт 9. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2020	2021	2022	2023	2024		
		Нийт				Нийт	Хот хооронд	Хот суурин газар
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	19,239	19,548	19,676	20,026	20,026	19,899	127
2	Мобиком нэтворкс ХХК	12,572*	12,895*	13,064*	14,597*	15,603*	12,939*	2,664*
3	Скайнэтворкс ХХК	11,960	12,195	12,624	13,440	14,070	11,190	2,880
4	Жемнэт ХХК	2,265	2,265	2,265	2,265	2,265	2,265	
5	МТ Нэтворкс ХХК	241	241	723	1237	1,237	1,237	
6	Айрон товер ХХК	65	134	134	134	134	65	69
7	Эс ти би эс ХХК			120	120	120		120
8	Скайстрим ХХК					46		46
9	Ондо нэтворкс ХХК			40	40	40		40
Нийт урт		46,342	47,278	48,644	51,939	53,540	47,594	5,946

\* радио релейний сүлжээний урт нэмэгдсэн

Харилцаа холбооны сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2024 онд хот хооронд 430 км, хот суурин газарт 682 км шилэн кабелийн сүлжээ шинээр байгуулсан байна.

Сүлжээний үйлчилгээ эрхлэгчдээс Мобиком нэтворкс ХХК радио релейний сүлжээтэй ба 2024 оны жилийн эцсийн мэдээллээр хот хооронд 4,462 км, хот суурин газарт 2,566 км радио релейний сүлжээтэй байна.

Зураг 7. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2024




Хот хоорондын шилэн кабелийн үндсэн сүлжээний урт 43,132 км ба үүний 46.13 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн сүлжээ бүрдүүлж байгаа бол 25.94 хувийг Скайнэтворкс ХХК, 19.65 хувийг Мобиком нэтворкс ХХК-ийн байгуулсан сүлжээ тус тус бүрдүүлж байна.

### 4.3. Улс хоорондын сүлжээний үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд улс хоорондын сүлжээний үйлчилгээ үзүүлэгч компаниуд БНХАУ, ОХУ, Хонгконг, АНУ, ХБНГУ, Япон улсын компаниудаар дамжуулан Ази, Европын үндсэн порттой шууд холбогдож, интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлж байна.

Интернэтийн гадаад урсгалын багтаамж 2024 оны жилийн эцэст 750.0 Гбит/сек болсон нь 2023 оны жилийн эцсийн үеэс 159.5 Гбит/сек-ээр буюу 27.01 хувиар нэмэгджээ. Харин интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд гэрээлсэн урсгал 228.7 Гбит/сек ба 2023 оны жилийн эцсээс 7.16 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 8. Интернэтийн гадаад урсгалын багтаамж, ашиглалт



2024 оны байдлаар нийт 54 интернэтийн үйлчилгээ эрхлэгч (давхардсан тоогоор) улс хоорондын сүлжээ эзэмшигчдээс гадаад интернэтийн урсгал түрээслэж байна.

### 4.4. Улс хоорондын транзит үйлчилгээ

Улс хооронд транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээг Жемнэт ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мобиком нэтворкс ХХК-иуд үзүүлж, нийт 2,200 Гбит/сек урсгалыг түрээслүүлж байна.

Түрээслүүлж буй транзит урсгалын хэмжээ өмнөх оноос 22.22 хувиар өссөн бол тус үйлчилгээний орлого 2024 онд 21.99 тэрбум төгрөг болж өмнөх оноос 16.70 хувиар буурсан байна.

## Хүснэгт 10. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024
Урсгалын хэмжээ, Гбит/сек	750	780	1370	1700	1800	2200
Орлого Тэрбум төгрөг	17.3	18.4	22.0	28.8	26.4	21.99

## 4.5. Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 аж ахуйн нэгж, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээг 3 аж ахуйн нэгж тус тус эзэмшиж, сүлжээний түрээс, яриа, интернэтийн үйлчилгээ үзүүлж байна.

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний орлого 2024 онд өмнөх оноос 1.63 хувиар өссөн байна.

## Хүснэгт 11. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэгчдийн орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр


Үзүүлэлт	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	8.09	7.33	7.46	1.63%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.94	0.67	0.71	6.00%
Хөрөнгө оруулалт	-	0.09	-	


Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс Исатком ХХК нь тусгай зөвшөөрлийн гэрээний хүрээнд эцсийн хэрэглэгчид сансрын холбооны VSAT сүлжээгээр дамжуулан интернэт, ярианы үйлчилгээг үзүүлж байна.

2023 онд Старлинк Сервисес Монголиа ХХК харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авч, нам орбитын хиймэл дагуулын сүлжээгээр интернэтийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус үйлчилгээний хэрэглэгч 1497 байна.

## Хүснэгт 12. Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Исатком ХХК	438	438	366	366	285
2	Старлинк сервисес Монголиа ХХК					1,497





## 5. ҮҮРЭН ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үүрэн холбооны яриа, мессеж болон интернэт үйлчилгээг 5 компани үзүүлж байна. 2024 онд тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлогын 57.26 хувь, хөрөнгө оруулалтын 61.55 хувийг үүрэн холбооны компаниуд бүрдүүлжээ.

Монгол Улс үүрэн холбооны үйлчилгээний 3G технологийг 2008 онд, 4G технологийг 2016 онд зах зээлд нэвтрүүлж байсан бол 5G технологийн туршилтыг 2022 онд эхлүүлсэн.



Хүснэгт 13. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК	38.64%	37.80%	38.03%	38.17%	38.30%	37.95%	36.85%	36.55%
СКАЙТЕЛ ХХК	15.25%	16.51%	17.43%	18.06%	17.65%	17.50%	18.62%	17.66%
ЮНИТЕЛ ХХК	35.16%	34.03%	33.08%	32.20%	34.34%	34.04%	32.24%	32.50%
ЖИ-МОБАЙЛ ХХК	10.95%	11.66%	11.46%	11.58%	9.71%	9.66%	9.49%	9.41%
ОНДО ХХК						0.85%	2.80%	3.88%

### 5.1. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

2024 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны үйлчилгээний орлого 1.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 15.81 хувиар өсчээ.

Зураг 9. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, оноор



Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид 2024 онд 216.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оноос 19.29 хувиар буурсан бол 273.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх оноос 22.61 хувиар өссөн байна.

### Хүснэгт 14. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилээр


Үзүүлэлт	2022	2023	2024	Сүүлийн жилийн өөрчлөлт
	Тэрбум төгрөг			
Орлого	1,039.76	1,190.78	1,379.02	15.81%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	189.53	223.22	273.70	22.61%
Хөрөнгө оруулалт	243.60	268.41	216.64	-19.29%


2007 онд үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын 90 орчим хувийг ярианы үйлчилгээ дангаар эзэлж байсан бол 2008 оноос өндөр хурдны 3G үйлчилгээ, 2016 онд LTE үйлчилгээ нэвтэрснээс хойш хэрэглэгчийн хандлага ярианаас дата үйлчилгээ рүү шилжиж, жилээс жилд ярианы үйлчилгээний орлого буурч, дата үйлчилгээний орлого өсч байна.

### Хүснэгт 15. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлого, оноор


Орлогын бүтэц	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
	Нийт орлогод эзлэх %							
Яриа	47.70	38.70	37.55	36.67	34.29	35.35	24.35	24.80
Дата үйлчилгээ	14.90	21.60	25.00	28.27	32.35	31.26	42.98	43.72
Богино үсэгт мэдээ	5.54	6.71	4.10	3.85	3.35	3.79	3.18	1.34
Харилцан холболт	9.02	7.89	7.08	7.20	6.90	6.15	5.40	4.84
Дамжуулан холболт	0.58	0.01	0.01	0.02	0.02	0.01	0.01	0.01
Нэмэлт үйлчилгээ	5.70	4.32	4.26	5.01	4.61	3.96	3.53	3.36
Улс хоорондын роуминг	1.09	0.99	1.10	0.18	0.12	0.28	0.72	1.34
Гар утас, модем	11.12	12.42	13.52	11.06	11.51	11.97	12.63	13.16
Бусад	4.36	7.36	7.37	7.75	6.85	7.22	7.19	7.43

Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) 20,548 төгрөг болж, 2023 оноос 4,004 төгрөгөөр нэмэгдсэн байна.





Зураг 10. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU)




### 5.2. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгч 4,889,043 болж өмнөх оноос 0.97 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ногдох үзүүлэлт нь 140.7 болж өмнөх оноос 0.4 нэгжээр буурсан байна.

Энэ үзүүлэлт нь дэлхийн орнуудын дундажтай харьцуулахад 28.7 нэгжээр өндөр үзүүлэлт юм. (хүснэгт 16)


Зураг 11. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор



Хүснэгт 16. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин


	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Дэлхийн дундаж	97	101	103	105	106	105	106	108	110.6	112
Монгол улс	103.1	110.7	125.2	133.3	136.7	132.6	140.4	142.8	141.1	140.7

Эх сурвалж: ITU DataHub



Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 60.6 хувийг урьдчилсан төлбөрт, 27.2 хувийг дараа төлбөрт, 12.2 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байна. Жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт хэлбэрт шилжих хандлагатай байна.

Зураг 12. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцлөөр зах зээлд эзлэх хувь, оноор




Үүрэн холбооны сүлжээнд нийт 4.1 сая хэрэглэгч хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт хэрэглэж байгаа нь өмнөх оноос 0.36 хувиар өссөн байна. Тус хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн 8.95 хувийг дата (only data) хэрэглэгч эзэлж байгаа нь өмнөх жилээс 0.16 хувиар буурсан байна.

Хүснэгт 17. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо, оноор


Он	Дата ба яриа хосолсон	Зөвхөн дата (Only data)	Нийт
2020	3,353,188	226,583	3,579,771
2021	3,633,268	255,971	3,889,239
2022	3,644,821	352,079	3,996,900
2023	3,751,283	371,083	4,122,366
2024	3,766,868	370,485	4,137,353

Үүрэн холбооны 3G сүлжээ Монгол Улсын 345 сум, суурин газарт нэвтэрч, 3G хэрэглэгчийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.8 саяд хүрч, 2023 онтой харьцуулахад 7.35 хувиар өссөн байна.

Харин 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 4.0 саяд хүрч, өмнөх оноос 17.3 хувиар өссөн.



Зураг 13. 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян





Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид LTE сүлжээнд смарт бокс ашигласан “Гэр”, “Манай”, “Скайнэт” зэрэг интернэт үйлчилгээг санал болгож буй бөгөөд тэдгээр хэрэглэгчийн тоо 2024 оны байдлаар 132,197 байгаа нь өмнөх оноос 2.24 хувиар буурсан байна.

Хүснэгт 18. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо

	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Хөдөлгөөнт өргөн зурвас LTE Смарт бокс хэрэглэгч	101,959	102,185	114,602	136,030	133,851	135,223	132,197


Үүрэн холбооны сүлжээн дэх машин буюу төхөөрөмжийн (M2M) тоо 190,995 болсон нь өмнөх оноос 14.65 хувиар өссөн байна.

Зураг 14. M2M хэрэглэгчийн тоо, оноор




“M2M хэрэглэгч” гэж машин буюу төхөөрөмж хооронд (автомашины GPS, ТҮЦ машин, төлбөр тооцооны PoS машин, камер, ухаалаг тоолуур, гэрийн ухаалаг төхөөрөмжүүд гм), хүний оролцоогүйгээр өгөгдөл дамжуулах зорилгоор ашиглаж буй сим карт буюу хэрэглэгчийн тоо юм. M2M мобайл сүлжээ хэрэглэгч нь ямар нэг хувь хүнд хамаарахгүй, тухайн төхөөрөмжийг хэд хэдэн хүн ашиглах боломжтой байдгаараа онцлогтой.


Зураг 15. Ухаалаг төхөөрөмжийн төрөл, 2024 он



Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 4,283,341-д хүрч өмнөх оноос 4.80 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн ухаалаг төхөөрөмжийн 64.59 хувийг Андроид, 32.22 хувийг Apple IOS үйлдлийн систем бүхий төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд Apple IOS төхөөрөмжийн хэрэглээ өмнөх оноос 3.38 хувиар өсчээ.

Зураг 16. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо






### Үүрэн холбооны сүлжээ

Үүрэн холбооны сүлжээ жил ирэх бүр хүрээгээ тэлж бааз станцын тоо нийт дүнгээр өмнөх оноос 9.64 хувиар нэмэгджээ. Нийт бааз станцын 56.88 хувийг 4G сүлжээний, 21.25 хувийг 3G сүлжээний, 19.20 хувийг 2G сүлжээний бааз станц бүрдүүлж байна.


Хүснэгт 19. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр, оноор

Он	2G	3G	4G	Нийт
2020	2,480	2,691	3,656	8,827
2021	2,734	2,980	4,344	10,058
2022	2,753	3,128	5,769	11,650
2023	2,969	3,453	8,471	14,893
2024	3,135	3,469	9,724	16,328

Зураг 17. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр, оноор





Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн тоог Улаанбаатар хот, аймаг, бүс нутгийн хүн амын тоотой харьцуулахад 4G/LTE хэрэглэгчийн нэвтрэлт баруун бүсэд хамгийн бага буюу 80.07 хувьтай байгаа бол Улаанбаатар хотод 135.07 хувьд хүрсэн байна.




Хүснэгт 20. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо, технологийн төрөл, бүс, байршлаар, 2024 он

Бүс, аймаг	Хүн ам	Хэрэглэгчийн тоо, төрлөөр			
		Нийт үүрэн холбоо	2G	3G	4G/LTE
<b>НИЙТ</b>	<b>3,544,835</b>	<b>4,889,043</b>	<b>2,751,282</b>	<b>3,838,038</b>	<b>4,037,902</b>
		<b>137.92%</b>	<b>77.61%</b>	<b>108.27%</b>	<b>113.91%</b>
<b>БАРУУН БҮС</b>	<b>422,845</b>	<b>465,956</b>	<b>270,526</b>	<b>306,053</b>	<b>338,573</b>
БАЯН-ӨЛГИЙ	118,275	105,191	65,515	67,231	84,644
ГОВЬ-АЛТАЙ	56,523	92,698	54,967	62,265	69,603
ЗАВХАН	70,719	92,229	44,299	55,162	54,118
УВС	84,911	104,538	63,765	72,956	79,266
ХОВД	92,417	71,300	41,980	48,439	50,942
<b>ХАНГАЙН БҮС</b>	<b>602,597</b>	<b>686,006</b>	<b>420,158</b>	<b>496,069</b>	<b>512,300</b>
АРХАНГАЙ	91,559	104,188	64,301	69,933	73,716
БАЯНХОНГОР	88,029	98,895	65,027	69,828	72,179
БУЛГАН	60,332	63,750	39,889	42,174	48,444
ОРХОН	111,890	129,781	81,220	113,540	117,202
ӨВӨРХАНГАЙ	114,351	119,121	66,745	91,019	85,957
ХӨВСГӨЛ	136,436	170,271	102,976	109,575	114,802
<b>ТӨВИЙН БҮС</b>	<b>521,667</b>	<b>729,871</b>	<b>451,265</b>	<b>575,519</b>	<b>592,901</b>
ГОВЬСҮМБЭР	18,159	22,270	14,362	19,089	18,107
ДАРХАН -УУЛ	110,544	135,350	78,558	112,717	118,542
ДОРНОГОВЬ	72,097	112,670	66,557	90,585	89,500
ДУНДГОВЬ	45,900	56,321	32,239	40,561	37,540
ӨМНӨГОВЬ	77,370	166,971	110,139	131,886	140,294
СЭЛЭНГЭ	106,042	117,288	70,768	92,663	97,678
ТӨВ	91,555	119,001	78,642	88,018	91,240
<b>ЗҮҮН БҮС</b>	<b>229,575</b>	<b>300,144</b>	<b>166,861</b>	<b>203,417</b>	<b>205,962</b>
ДОРНОД	84,604	101,409	68,122	78,577	79,832
СҮХБААТАР	65,791	84,503	45,291	50,157	59,466
ХЭНТИЙ	79,180	114,232	53,448	74,683	66,664
<b>УЛААНБААТАР</b>	<b>1,768,151</b>	<b>2,707,066</b>	<b>1,442,472</b>	<b>2,256,980</b>	<b>2,388,166</b>
		<b>153.10%</b>	<b>81.58%</b>	<b>127.65%</b>	<b>135.07%</b>






